

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны .. дүгээр сарын ...

Улаанбаатар хот

Дугаар ...

АЛДАНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1.Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.051 хувь, татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.042 хувь байхаар тогтоож, 2025 оны татварын жилд мөрдсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

ТАНИЛЦУУЛГА

"Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай"

Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт "Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт, эсхүл татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тус тус алданги тооцох бөгөөд тухайн татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 01 дүгээр сард багтаан дараах зарчмыг үндэслэн тогтооно." гэж заасны дагуу 2025 оны татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг тогтоох тухай Сангийн сайдын тушаалын төслийг боловсрууллаа.

Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх хэсэгт "татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкнуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байхаар" гэж заасны дагуу алдангийн хэмжээг өмнөх жилүүдэд алдангийн хэмжээг тогтооход баримталсан зарчмын дагуу Монголбанкнаас зарласан арилжааны банкнуудын 2024 оны зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дундаж хэмжээнд үндэслэн тогтоолоо¹.

Улмаар, татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.051 хувь, татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.042 хувь байхаар тогтоож, 2025 оны татварын жилд мөрдөхөөр тушаалын төсөлд тусгав.

¹ <https://stat.mongolbank.mn/>